

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ-ИЙН 2025 эхний хагас жилийн тайлан

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

УИХ-ын 2017 оны 11 сарын 28-ны өдрийн “Санхүүжилтийн хэлэлцээр батлах тухай” тогтоолын дагуу Монгол улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банк (АХБ) хооронд хөнгөлөлттэй зээлийн гэрээг 2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр байгуулж, 4 дүгээр сарын 30-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

Төслийн нэр, дугаар	L3605/G9191:Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл
Хөгжлийн түнш	Азийн хөгжлийн банк
Төслийн өртөг	27.27 сая ам. доллар
Санхүүжилтийн хэлбэр	L3605-MON (Зээл), G9191-MON (Буцалтгүй тусламж)
Санхүүжилтийн хэлэлцээр батлагдсан огноо	2017 оны 11 дүгээр сарын 28
Төсөл эхэлсэн огноо Төсөл дуусах огноо Төслийн хугацаа сунгасан огноо Сунгалтын хугацаа Төсөл дуусах огноо	2018 оны 4 дүгээр сарын 30 2022 оны 10 дугаар сарын 31 2021 оны 12 дугаар сарын 06 (24 сараар) 2024 оны 4 дүгээр сарын 01 (24 сараар) 48 сар 2026 оны 10 дугаар сарын 31
Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам/ГБХНХЯ Эрүүл мэндийн яам
Төслийн захирал	ГБХНХЯ-ны Гэр бүлийн бодлогын газрын дарга Ц.Мөнхзул
Төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулсан тухай	“Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” Сангийн Сайдын 2021 оны 7 дугаар 2-ны өдрийн 107 тоот тушаал
Төсөл хэрэгжүүлэх нэгжийн батлагдсан орон тоо	Нийт орон тоо 15.
Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч, и-майл хаяг	Төслийн зохицуулагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Асыл Х.Асыл asyl@pwpdp.mn
Төслийн нэгжийн байршил, холбоо барих	Монгол улс, Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг VII хороо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн 5 дугаар давхарт ТХН-ийн утас (976) 77337755 И-майл хаяг: info@pwpdp.mn

2. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

2.1 Төслийн зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл (Төсөл гэх) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой.

2.2 Төслийн үр нөлөө, үр дүн

Төслийн эцсийн үр дүн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бие даах чадварыг дээшлүүлж, нийгэм эдийн засагт тэдний оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ. эхийн тулд хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн эрхийн тухай НҮБ-ын Конвенц, Инчеоны стратегийг хэрэгжүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хувь нэмэр оруулна¹.

2.3 Төслийн зорилт, арга хэмжээ

Төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчдэд чиглэсэн хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, нийгмийн хөгжлийн үйлчилгээ, орчны хүртээмж, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр Засгийн газрын бодлого, хэрэгжилтийг дэмжихэд чиглэсэн дараах 5 бүрэлдэхүүн хэсэгтэй.

Монгол Улсын Засгийн Газар, Азийн хөгжлийн банк (АХБ)-ны харилцан зөвшилцсөнөөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам/ГБХНХЯ (Зорилт 2, 3, 4, 5), Эрүүл мэндийн яам (Зорилт 1, 5-ын үйлдлийн олон улсын ангилал) хэрэгжүүлж байна.

Хүснэгт 1. Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд, арга хэмжээ

Зорилт	Арга хэмжээ/үйл ажиллагаа
Бүрэлдэхүүн 1. Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чадавх бэхжүүлж институтчилэх	1.1 Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх тогтолцоог институтчилэх 1.2 Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх ур чадварыг хөгжүүлэх замаар эрт илрүүлэлтийг эмнэлгийн аргачлалаас нийгмийн загварт шилжүүлэх
Бүрэлдэхүүн 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах	2.1 Хүүхдийн бага насанд "Эцэг, эх-хүүхэд-чиглүүлэгч" боловсролын оролцооны хөтөлбөрийн загвар хэрэгжүүлэх 2.2 Төсөл хэрэгжих 7 аймаг, нийслэлийн нэг дүүрэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв байгуулах 2.3 Хэл засалч, хөдөлгөөн засалч, туслах технологи, хэрэгслийн техникч, нийгмийн ажилтнууд зэрэг сэргээн засахын хүний нөөцийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх 2.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дэмжих нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах

¹ НҮБ, 2016, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ийн Конвенц

	2.5 Хөгжлийн бэрхшээлтэй хүнд мэдээлэл, зөвлөгөө, лавлагаа өгөх шууд утасны үйлчилгээг дэмжих
Бүрэлдэхүүн 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн орчны хүртээмжийг сайжруулах	3.1 Шийдвэр гаргагчид, орчны хүртээмж (дэд бүтэц, тээвэр, мэдээлэл)-ийн хэм хэмжээг зохицуулсан хууль эрхзүйн зохицуулалтын хэрэгжилтийг хангуулах институтийн чадавхыг бэхжүүлэх 3.2 Хууль дагаж мөрдүүлэх механизмд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг өргөнөөр татан оролцуулах 3.3 Шаардлагад нийцсэн чанартай туслах технологи, хэрэгслийн хүртээмжийг сайжруулах
Бүрэлдэхүүн 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	4.1 Үйлдвэрлэлийн тодорхой салбарт ажиллах хөгжлийн бэрхшээлтэй хүний ур чадварыг дээшлүүлэх, ажлын байранд бэлтгэх, хөдөлмөр зуучлалын үйлчилгээг сайжруулах 4.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүний тогтмол ажлын байр, хувиараа хөдөлмөр эрхлэх болон оролцоотой бизнесийн хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх 4.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг зохицуулсан хууль, журмыг дагаж мөрдүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоотой хяналт тавих механизмыг дэмжих
Бүрэлдэхүүн 5. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дэмжих стратеги боловсруулж, хэрэгжүүлэх	5.1 Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг сайжруулах 5.2 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагад үндэслэн зорилтот бүлгийг оновчтой тодорхойлох, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамжийн тэтгэвэр, үйлчилгээний дэмжлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр нийгмийн халамжийн шинэчлэл хийх, үйлчилгээ, тоног төхөөрөмжийн хүртээмжийг сайжруулах 5.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, бодлогын шинэчлэл хийх 5.4 Эрэлт хэрэгцээ, санхүүгийн нөөцтэй уялдуулан үйлдлийн олон улсын ангиллыг туршилтаар хэрэгжүүлэх 5.5 Хөгжлийн бэрхшээлийн мэдээллийн эрэлт хэрэгцээтэй нийцүүлэн статистик мэдээллийн арга зүйг боловсронгуй болгох

2.4 Төслийн хэрэгжилтийн хугацаа

Төсөл 2018 оны 4 дүгээр сараас 2026 оны 10 дугаар сар дуустал хугацаанд нийт 8 жил 6 сар үргэлжлэх бөгөөд үүнээс өнөөгийн байдлаар төсөл хэрэгжих нийт хугацааны 82 хувь (7 жил) өнгөрч нь байна.

Дараах нөхцөл байдалтай холбогдуулан төслийн хэрэгжилтийн хугацааг 2 удаа сунгасан. Үүнд:

- Ковидын нөхцөл байдлын улмаас төслийн зарим үйл ажиллагаа тухайлбал 6 аймагт шинээр байгуулж байгаа Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвд ажиллах хүний нөөцийн чадавх бэхжүүлэх сургалтууд, ажлын байрны дадлага ажлууд танхимын нөхцөлд хийх шаардлагатай зарим арга хэмжээ хойшлогдсон, Улаанбаатар хотод барих Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг

дэмжих төвийн барилгын зураг төсөл боловсруулах явцад барилга барихаар анх төлөвлөж байсан байршилд дэд бүтцийн асуудалтай тулгарсан тул дахин газар төлөвлөх шаардлагатай болсноор барилга угсралтын ажил хойшлогдсон зэргийг үндэслэн Зээл хүлээн авагч тал (Монгол Улс)-ын хүсэлтийн дагуу Азийн хөгжлийн банк төслийн хугацааг 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 2 жилийн хугацаатай сунгасан.

- Хөнгөлөлттэй зээлээс хэмнэгдэж буй эх үүсвэрийг ашиглах замаар Завхан аймагт, нийслэлийн Баянзүрх дүүрэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилга нэмж барихаар Зээл хүлээн авагч тал (Монгол Улс)-2023 оны 11 дүгээр сард АХБ-д хүсэлт тавьснаар хоёр төвийн барилга угсралтын ажилтай уялдуулан төслийн хугацааг 2026 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 2 жилээр сунгасан.

2.5 Төслийн санхүүжилтийн эх үүсвэр

Төслийн нийт санхүүжилт 27.27 сая ам. доллар, үүнээс АХБ-ны хөнгөлөлттэй зээл 27 сая ам.доллар, Ядуурлыг бууруулах Японы сангийн буцалтгүй тусламж 2 сая ам.доллар, Монгол Улсын Засгийн газрын оролцоо 270 мянган ам.доллар /биет бус хэлбэрээр/ байна.

		Хүснэгт 1
д/д	Санхүүжилтийн эх үүсвэр	Дүн /Ам.доллар/
1	АХБ-ны хөнгөлөлттэй зээл	25,000.000
2	Ядуурлыг бууруулах Япон сангийн буцалтгүй тусламж	2,000.000
3	Монгол Улсын Засгийн Газар	270.000
	Нийт	27,270.000

2.6 Төслийн Удирдах Хороо

“Сангийн сайдын 2021 оны Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх тухай” 4 дүгээр журмын 7.10.1-д “Төсөл, арга хэмжээний зорилгыг тогтоосон хугацаанд, бүрэн хэрэгжүүлэх зорилгоор хэрэгжилтийг нэгдсэн бодлого, удирдлагаар хангаж, салбарын бодлоготой уялдуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус нэгж болох Төслийн удирдах хороог төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр байгуулна” гэж заасан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн А/232 тоот тушаалаар Төслийн удирдах хороо байгуулж, даргаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд, гишүүдэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), Сангийн яам (СЯ), Эрүүл мэндийн яам (ЭМЯ), Барилга хот, байгуулалтын яам (БХБЯ), Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ), Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар (ХБХХЕГ), Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ), Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Хөгжлийн бэрхшээлтэй иргэд Төрийн бус байгууллага (ХБИТББ)-уудын төлөөллүүд байсан.

Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дараа Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт орж Төслийн Удирдах хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэх шаардлага гарсан. ГБХНХ-ын Сайдын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/64 тоот тушаалаар Төслийн Удирдах Хороог шинэчлэн байгуулсан.Үүнд:

- ТУХ-ны даргаар ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга
- Гишүүдэд Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, ГБХНХЯ-ны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Гэр бүлийн

бодлогын газрын дарга, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газрын дарга Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга, ГБХНХ-ын Сайдын хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөх, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо ТББ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо ТББ, Нарийн бичгийн даргаар Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагчийг томилсон.

Төслийн удирдлага, зохион байгуулалтын бүдүүвчийг Зураг 1-д харуулав.

Зураг 1. Төслийн удирдлага, зохион байгуулалт



2.7 Дэд хороод ба Ажлын хэсгүүд

- Төсөл хэрэгжиж байгаа Архангай, Дархан-уул, Дорнод, Дундговь, Ховд, Хөвсгөл аймагт төслийн дэд хороо байгуулж аймгийн Засаг дарга ахалж, хорооны бүрэлдэхүүнд аймгийн нийгмийн бодлого, хөдөлмөр, халамж үйлчилгээ, эрүүл мэнд, боловсрол, соёл, гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжил, мэргэжлийн хяналт, аймгийн ерөнхий архитектур, барилга, дэд бүтцийн асуудал хариуцсан төрийн байгууллагууд болон аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ, холбоодын

төлөөллөөс бүрдэж байна. Дэд хороо нь төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих, хөгжлийн төвийн хүний нөөцийг бэлтгэх, ажилтнуудыг сургалтад хамруулж чадавх бэхжүүлэх, хөгжлийн төвийн барилга угсралтын ажлын явцад дэмжлэг үзүүлж ажилласан.

- “Ажлын хэсэг байгуулах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 2019 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/382 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орчны хүртээмжийг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр зөвлөх үйлчилгээний явцад мэдээллээр хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, тайлан зөвлөмжтэй танилцах, бүтээгдэхүүн хүлээж авахад дүгнэлт гаргах зэргээр төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн ажилласан.
- “Хэвлэл мэдээллийн удирдах зөвлөл байгуулах тухай” ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 5 сарын 21-ний өдрийн А/178 дугаар тушаалаар байгуулагдсан хэвлэл мэдээллийн Удирдах зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг сайжруулах стратеги боловсруулан хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй ажилласан.
- “Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамж шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/213/А77 дугаар хамтарсан тушаалаар хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх тогтолцоог бүрдүүлэх, нэвтрүүлэх, чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх техникийн ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.
- “Ажлын хэсэг байгуулах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/112, А/87 дугаар хамтарсан тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх анхдагч мэдээллийн сан байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.
- “Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамж батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн А/76, А/183 дугаар хамтарсан тушаалаар үйлдлийн олон улсын ангиллыг нэвтрүүлэх зорилгоор туршилтын төслийг төсөл хэрэгжиж байгаа 6 аймагт хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

2.8 Төсөл хэрэгжүүлэх нэгж

Төсөл хэрэгжүүлэх нэгж 2018 оны 7 дугаар сард байгуулагдсан, нэгжийн бүтэц, орон тоог хоёр удаа шинэчлэн баталсан. Үүнд:

- “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог батлах тухай” Сангийн сайдын 2018 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 186 тоот тушаалаар төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэн зохицуулах үүрэг бүхий Төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулж i) төслийн зохицуулагч-1, ii) худалдан авах ажиллагааны ажилтан-1, iii) санхүүгийн ажилтан-1, iv) хяналт шинжилгээ, үнэлгээний ажилтан-1; v) хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцсан ажилтан-2, vi) төслийн захиргааны ажилтан-1, vii) жолооч-1 **нийт 8 орон тоо** баталсан.
- “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2019 оны 4 сарын 30-ны өдрийн 97 тоот тушаалаар i) төслийн зохицуулагч-1, ii) дэд зохицуулагч-6, iii) худалдан авах ажиллагааны ажилтан-1, iv) санхүүгийн ажилтан-1, v) хяналт шинжилгээ, үнэлгээний ажилтан-1; vi) хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцсан ажилтан-2, vii) төслийн захиргааны ажилтан-1, viii) жолооч-1 **нийт 14 орон тоо** баталсан. Төсөл хэрэгжиж байгаа 6 аймагт ажиллах “Дэд зохицуулагчийн”-ийн 6 орон тоо нэмж баталсан.

- “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” Сангийн Сайдын 2021 оны 7 дугаар 2-ны өдрийн 107 тоот тушаалаар i) төслийн зохицуулагч-1, ii) дэд зохицуулагч-6, iii) худалдан авах ажиллагааны ажилтан-1, iv) санхүүгийн ажилтан-1, v) хяналт шинжилгээ, үнэлгээний ажилтан-1; vi) хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцсан ажилтан-2, vii) барилгын инженер-1 viii) төслийн захиргааны ажилтан-1, ix) жолооч-1 **нийт 15 орон тоо** баталсан. Төсөл хэрэгжиж байгаа 6 аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгын ажил эхэлсэнтэй холбогдуулан тогтмол хяналт тавих, мэргэжил, арга зүйгээр хангах “Барилгын инженер”-ийн 1 орон тоо нэмж баталсан.

Хүснэгт 2. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн орон тоо

д/д	Албан тушаал	“Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог батлах тухай” Сангийн сайдын 2018 оны 7 сарын 17-ны өдрийн 186 тоот тушаалаар батлагдсан орон тоо	“Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2019 оны 4 сарын 30-ны өдрийн 97 тоот тушаалаар батлагдсан орон тоо	“Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2021 оны 7 сарын 02-ны өдрийн 107 тоот тушаалаар батлагдсан орон тоо	2025 оны 6 дугаар сарын 01-ний байдлаар ажиллаж байгаа
1	Төслийн зохицуулагч	1	1	1	Х.Асыл
2	Дэд зохицуулагч		6	6	Л.Цэрэннямбуу
3	Санхүүгийн ажилтан	1	1	1	Р.Баярмаа
4	Худалдан авах ажиллагааны ажилтан	1	1	1	Х.Асыл
5	Хяналт шинжилгээ, үнэлгээний ажилтан	1	1	1	А.Энхтүвшин
6	Хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	2	2	2	Н.Оюунгэрэл
7	Барилгын инженер			1	Д.Ариунгэрэл
8	Захиргааны туслах ажилтан	1	1	1	Г.Золзаяа
9	Жолооч	1	1	1	Д.Доржпүрэв
	НИЙТ	8	14	15	8

2025 оны 6 дугаар сарын 01-ний байдлаар Төсөл хэрэгжүүлэх нэгжид 10 орон тоотойгоор ажиллахаас 8 ажилтан ажиллаж байна. Төслийн зохицуулагч З.Мөнхзул 2024 оны 5 дугаар сард ажлаас чөлөөлөгдсөн, зохицуулагчийн албан тушаалыг түр орлон гүйцэтгэгчээр худалдан авах ажиллагааны ажилтан Х.Асыл давхар хариуцаж байна.

Архангай аймаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгын ажилд өдөр тутам хяналт тавих, мэргэжил, арга зүйгээр хангах, төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд, орон нутгийн удирдлагыг нэгдсэн мэдээллээр хангах үүрэг бүхий дэд зохицуулагч/барилгын хяналтын инженерээр Л.Цэрэннямбуу 2025 оны 3 дугаар сараас, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн ажилтан Р.Баярмаа 2024 оны 10 дугаар сараас, хяналт шинжилгээ, үнэлгээний ажилтан А.Энхтүвшин 2020 оны 3 дугаар сараас, хөгжлийн бэрхшээлийн ажилтан Х.Оюунгэрэл 2025 оны 3 дугаар

сараас, барилгын инженер Д.Ариунгэрэл 2024 оны 7 дугаар сараас, захиргааны туслах ажилтан Г.Золзаяа 2023 оны 6 дугаар сараас, жолооч Д.Доржпүрэв 2024 оны 9 дүгээр сараас тус тус ажиллаж байна.

2.9 Төслийн төсөв, санхүүжилт

Төслийн хүрээнд байгуулсан гэрээний нийт үнийн дүн нь 18.809 сая ам.доллар буюу төсөвлөсөн дүнгийн 69.66 хувийг эзэлж байгаа бөгөөд нийт зарцуулалт нь 18.978 сая ам.доллар буюу төслийн санхүүжилтийн 70.29 хувьд хүрээд байна.

2025 оны 5 дугаар сарын 1-ний байдлаар төслийн L3605 зээлийн хүүгийн төлбөрийг хассан дүнгээр 6,910,664.39 ам.доллар, G9191 буцалтгүй тусламжийн санхүүжилтийн хувьд 282,440.67 ам.долларын зарцуулаагүй үлдэгдэл тус тус байна.

2.10 Төслийн бүрэлдэхүүн хэсэг бүрийн хэрэгжилтийн товч

Бүрэлдэхүүн 1. Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чадавх бэхжүүлж институтчилэх

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага Эрүүл мэндийн яамтай хамтран (ЭМЯ), (i) хүүхдийн өсөлт хөгжлийг хянах Эх хүүхдийн эрүүл мэндийн ягаан дэвтэрт “Монгол хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх түргэвчилсэн үнэлгээ- MORBAS” үнэлгээний асуумжийг шинээр боловсруулан тусгаж, хүүхдийг 9, 18, 36 сартайд нь эрүүл мэндийн анхан шатлалд үнэлэх тогтолцоог бэхжүүлсэн, Эрүүл мэндийн Сайдын 2023 оны А/347 дугаар тушаалаар батлагдсан, (ii) эрүүл мэндийн лавлагаа шатлалын эмнэлгүүдэд эрүүл мэндийн анхан шатлалаас илгээсэн хүүхдэд үзлэг хийх онош магадлах зорилгоор оношилгоо, үнэлгээ, шинжилгээ (доктор Бауманы аргачлал)-ний шинэ аргачлалыг нутагшуулах шатандаа байна.

Төслийн хүрээнд эрүүл мэндийн анхан шатлалын өрх, сумын эрүүл мэндийн төвийн (1254 эмч мэргэжилтэн), лавлагаа шатлалын эмнэлгийн (43 эмч мэргэжилтэн) эмнэлгийн мэргэжилтнүүд болон төсөл хэрэгжиж байгаа 6 аймаг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төв болон салбар комиссын гишүүдийг хүүхдийн хөгжлийн үнэлгээний шинэчлэн баталсан арга, аргачлалд сургах цуврал сургалтууд зохион байгуулсан.

Бүрэлдэхүүн 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах

Төслийн хүрээнд долоон аймаг, нийслэлийн Баянзүрх дүүрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн түгээмэл загвар бүхий барилга барьж ашиглалтад оруулах, сэргээн засах, хөдөлмөр засал, хэл яриа засал, сэтгэл засал, ортопедын засвар үйлчилгээ, хүүхдийн эрт үеийн хөгжил, боловсролын Портеж хөтөлбөрийн үйлчилгээ зэрэг өргөн хүрээний үйлчилгээний шинэ концепц нэвтрүүлж байна. Өнөөгийн байдлаар найман ХБХХТТ байгуулахаас таван төв (Дархан-уул, Дорнод, Дундговь, Ховд, Хөвсгөл) хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйлчилгээ үзүүлж байна. Төслийн зөвлөхүүдийн дэвшүүлсэн санал, зөвлөмж дээр үндэслэн (i) ХБХХТ-ийн үндсэн үйлчилгээний журам, заавар боловсруулах, түүнчлэн (ii) хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл ярианы засалч, туслах технологийн техникч зэрэг техникийн түвшний хүний нөөцийн хомсдолыг арилгах арга хэмжээ авах шаардлагатай байна.

Архангай аймаг дахь ХБХХТ. Архангай аймаг дахь ХБХХТ-ийн барилгын ажлын гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаандаа биелүүлээгүй, үүнээс шалтгаалан

захиалагчтай 2 жил гаруй үл ойлголцсоны эцэст гэрээг цаашид үргэлжлүүлэхээр зөвшилцөлд хүрсэн. Барилгын ажил 2025 оны 3 дугаар сард эхэлсэн. Өнөөгийн байдлаар барилгын ажлын гүйцэтгэл 70%-тай байна. гэрээний дагуу барилгын ажлыг 9 дүгээр сар гэхэд дуусгаж Улсын комисст хүлээлгэн өгнө.

Завхан аймаг дахь ХБХХТ-ийн барилгын инженерийн нарийвчилсан зураг, төсөв боловсруулж дууссан. Төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс барилга барих талбайн байгаль орчны болон нийгмийн хамгааллын бэлэн байдлын үнэлгээ хийсэн, холбогдох баримт бичгүүдийг шинэчилсэн, барилгын ажил гүйцэтгүүлэх тухай тендер 3 дугаар сард зарласан, 7 компани тендер ирүүлсэн боловч тендерийн шаардлага шаардлага хангаагүй тулд дахин зарласан. 6 дугаар сард багтаан гэрээ байгуулахаар төлөвлөж байна.

Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг дэх ХБХХТ-ийн барилга барих талбайн байгаль орчны болон нийгмийн хамгааллын бэлэн байдлын үнэлгээ хийсэн, нөлөөлөлд өртсөн нэг өрхөд зориулж залруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж АХБ-ны Нийгмийн хамгааллын бодлогод нийцэж байгаа эсэх талаар АХБ-наас санал авсан. Нөлөөлөлд өртсөн өрхөд чиглэсэн залруулах арга хэмжээний төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгасан. Үүнд:

- Санал болгож буй нөхөх олговрын талаар нөлөөлөлд өртсөн өрхөөс бичгээр зөвшөөрөл авах. Хөрөнгийн үнэлгээний компаниас хийсэн “Үл хөдлөх хөрөнгийн нөхөх олговор олгох зориулалттай үнэлгээ”-д үндэслэн (а) эд хөрөнгө, (б) түр суурьших зардал болон (с) нүүлгэн шилжүүлэлтийн зардалд нийт 18,691,169.0 төгрөгийн нөхөх олговор олгох.
- Нөлөөлөлд өртсөн өрхийн гишүүдийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалт, дадлагажигч ажилтан бэлтгэх сургалт, үйлчилгээнд хамруулж дэмжлэг үзүүлэх.
- Нөлөөлөлд өртсөн өрхийн тэргүүн болон том хүүгийн сонсголын түвшинг шалгах үзлэгт оруулах, сонсгол алдалтын зэргийг тодорхойлуулах, нийгмийн халамжийн тэтгэмж, үйлчилгээнд хамруулах.
- Нөлөөлөлд өртсөн өрхийн амьжиргааг тодорхойлох судалгаа, үнэлгээ хийх, хүнсний талоны хөтөлбөрийн шаардлагад нийцэж байгаа тохиолдолд хамруулах
- ХБХХТ ашиглалтад орж үйл ажиллагаагаа эхэлмэгц нөлөөлөлд өртсөн өрхийн наад зах нь нэг гишүүнийг ажлын байраар хангах.
- Нөлөөлөлд өртсөн өрхийн өнөөгийн амьдралын нөхцөл байдлыг үнэлэх, нөхцөл байдал тогтворжсон/дээрдсэн эсэхийг тогтоох, АХБ-д мэдэгдэх.

Нийслэлийн Баянзүрх дүүрэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгын ажил гүйцэтгүүлэх сонгон шалгаруулалт эхлүүлэхээс өмнө залруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг АХБ-д явуулж хянуулна. Залруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг үндэслэн нийгмийн хамгааллын нийцлийн бэлэн байдлын тайланг шинэчлэн АХБ-д хүргүүлнэ.

Нийслэлийн Баянзүрх дүүрэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгын ажил гүйцэтгүүлэх гэрээг 6 дугаар сарын эцэс гэхэд байгуулах, 2026 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд барилгын ажлыг дуусгах тухай АХБ-наас удаа дараа мэдэгдэж байна. Хэрэв барилгын ажлын гэрээ байгуулах хугацаа 2025 оны 7 дугаар сараас хойш хэтэрвэл төсөл хаагдах хугацаанд нөлөөлөх тул АХБ-наас гэрээ байгуулах зөвшөөрөл олгохгүй тухай мэдэгдсэн.

Бүрэлдэхүүн 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн орчны хүртээмжийг сайжруулах

Төслийн зөвлөхүүд хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн амьдралд бие даан оролцох саадгүй орчин бүрдүүлэх, төрийн үйлчилгээ, мэдээллийн болон барилга байгууламж, дэд бүтцийн ХБИ-д чиглээн хүртээмжийн хэм хэмжээг тогтоох “Саадгүй байдал, хүртээмжийн тухай” анхдагч хуулийн төслийг боловсруулсан. Түүнчлэн, бичвэрийг ярианд хөвүүлэх программ хангамжийг төрийн байгууллагуудын веб сайтад байршуулан хэрэглээг эрчимжүүлэх, хүртээмжтэй, чанартай ортопедийн хэрэгсэл, туслах технологийн хангамжийг сайжруулах стратегийн төслийг эцэслэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн боловсрол олгох сургуулийн хөгжлийн стратеги баримт бичгийн төсөл зэрэг бодлогын баримт бичгүүдийг зохих түвшинд батлуулах ажил ГБХНХЯ дээр хүлээгдэж байна.

Бүрэлдэхүүн 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

Төслийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг (ХБИХЭДТ) Улаанбаатар хотод байгуулж, 2024 оноос үйл ажиллагаа явуулж эхлүүлээд байна.

Тус байгууллагын бүтэц, дүрмийг Засгийн газрын 2024 оны 10 сарын 23 өдрийн 138 дугаар тогтоолоор баталсан. Уг төв нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ажил олгогчид сургалт хийх, ажил хөдөлмөрт зуучлах, хөгжлийн бэрхшээлтэй иргэн хувиараа хөдөлмөр эрхлэхэд бизнес инкубаторын үйлчилгээ үзүүлэх, ажлын байран дээр дадлагажуулах үйлчилгээ үзүүлнэ. Одоогийн байдлаар 13 ажилтан ажиллаж байна.

Төслийн зөвлөх нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн зарим үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх үйлчилгээний бизнесийн загвар боловсруулах зөвлөх үйлчилгээг гүйцэтгэж байна.

Бүрэлдэхүүн 5. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дэмжих стратеги боловсруулж, хэрэгжүүлэх

Төслийн зөвлөхүүд хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэх ажиллах чадамжийг үнэлэхэд зориулж ICF-д суурилсан хялбаршуулсан үнэлгээний аргачлалыг боловсруулж 20 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулан туршилт хийж, төрийн болон ТББ-ын 70 гаруй ажилтнуудад сургалт зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэх ажиллах чадварыг үнэлэхэд ICF-д суурилсан хялбаршуулсан үнэлгээний аргачлалыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн үйлчилгээнд турших ажил хийгдэж байна.

Төслийн зөвлөх нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх өнөөгийн статистик мэдээллийг Вашингтон бүлгийн зөвлөмж, Инчеоны стратегитай уялдааны талаар судалгаа хийж, статистик мэдээллийг сайжруулах чиглэлээр зөвлөмж боловсруулсан зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр ГБХНХЯ, ХБХХЕГ, ҮСХ-той хамтран ажиллах шаардлагатай байна.

2.11 Төслийн жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

Төслийн жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь 17 үйл ажиллагаа, 20 шалгуур үзүүлэлттэй. Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөө /ЖҮАТ/-ний хэрэгжилт, явцын дүн шинжилгээний тайланг хагас жилээр болон жилийн эцсийн байдлаар боловсруулж АХБ-д хүргүүлэн хянуулдаг.

Нийт 17 арга хэмжээ төлөвлөснөөс биелсэн 4, хэрэгжилтийн шатандаа 9, хугацаа болоогүй 4 байна. Шаогуур үзүүлэлтийн тухайд нийт 20 үзүүлэлтээс биелсэн 5, хэрэгжилтийн шатанд 8, хугацаа болоогүй 7 шалгуур үзүүлэлт байна. Түүнчлэн 3 үзүүлэлт төслийн хяналт шинжилгээ, үнэлгээний матрицтай уялдсан байна.

Хүснэгт 2. Жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт (2024 оны жилийн эцсийн байдлаар)

Жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний үйл ажиллагаа		Шалгуур үзүүлэлтийн биелэлтийн явц		Төслийн ХШҮ-ний матрицад хамаарах үзүүлэлт
17	Биелсэн: 4 2.2, 2.5, 5.1 болон 5.2	20	Биелсэн: 5 2.2, 2.5, 2.6, 5.1 болон 5.2	3
	Хэрэгжилтийн шатанд: 9 1.1, 1.2, 2.1, 2.3, 2.4, 2.6, 3.1, 5.3 болон 5.4		Хэрэгжилтийн шатанд: 8 1.1, 1.2, 2.1.1, 2.1.2, 2.1.3, 2.3, 2.4 болон 3.1	ЖҮАТ-ний шалгуур үзүүлэлт 3.1
	Хугацаа болоогүй: 4 4.1, 4.2, 4.3 болон 4.4		Хугацаа болоогүй: 7 4.1.1, 4.1.2, 4.2, 4.3, 4.4, 5.3 болон 5.4	ЖҮАТ-ний шалгуур үзүүлэлт 4.3 ЖҮАТ-ний шалгуур үзүүлэлт 4.4

Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн 2024 оны жилийн эцсийн тайланг

https://drive.google.com/drive/folders/1y5Twmu4rtg_ZWaR59YR-36lFBuMPcClh?usp=drive_link-д байршуулав.

2.12 Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

https://drive.google.com/drive/folders/1y5Twmu4rtg_ZWaR59YR-36lFBuMPcClh?usp=drive_link

2.13 Төслийн хяналт шинжилгээ үнэлгээний матриц

https://drive.google.com/drive/folders/1y5Twmu4rtg_ZWaR59YR-36lFBuMPcClh?usp=drive_link

2.14 Зөвлөх үйлчилгээний хэрэгжилт

https://drive.google.com/drive/folders/1y5Twmu4rtg_ZWaR59YR-36lFBuMPcClh?usp=drive_link

2.15 Барилгын ажлын гүйцэтгэл

https://drive.google.com/drive/folders/1y5Twmu4rtg_ZWaR59YR-36lFBuMPcClh?usp=drive_link

2.16 Төслийн хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжүүд

https://drive.google.com/drive/folders/1y5Twmu4rtg_ZWaR59YR-36lFBuMPcClh?usp=drive_link

2.17 Төслийн зөвлөхүүдийн боловсруулсан бодлогын баримт бичгийн төсөл, хэрэгжилт, явц

https://drive.google.com/drive/folders/1y5Twm4rtg_ZWaR59YR-36lFBuMPcClh?usp=drive_link

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ